



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй програм хооронд статистикийн мэдээ, мэдээлэл солилцох журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програмд илгээх өгөгдлийн жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 02 сарын 10-ны өдрийн  
А/67 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД АШИГЛАГДАЖ БУЙ ПРОГРАМ ХООРОНД СТАТИСТИКИЙН, МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ СОЛИЛЦОХ ЖУРАМ

### Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь эрүүл мэндийн салбарын бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээ, мэдээлэл хөрвүүлэх, солилцох, хадгалах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй програм хооронд статистик мэдээ, мэдээллийг солилцох журам нь Статистикийн тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Хувь хүний нууцийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг хувилбар 1.0 батлах тухай” 295 тоот тушаал, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### Хоёр: Үйл ажиллагаа

- 2.1. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програм “H-info” нь эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журмыг үндэслэсэн хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийг батлагдсан маягтын дагуу хүлээн авч, тайлан мэдээ, мэдээллийг нэгтгэх, боловсруулах зориулалт бүхий систембайна.
- 2.2. Эрүүл мэндийн байгууллага нь статистик мэдээллийг эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан урсгалын дагуу нэгтгэн, “Статистикийн тухай хууль”-ийг баримтлан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг ханган Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээнэ.
- 2.3. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заагдсан статистикийн мэдээ, мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програмд илгээх ба ингэхдээ тус төвтэй гэрээ байгуулж, холбогдох сүлжээ болон програм хангамжийн шийдлийг ашиглана.
- 2.4. Эрүүл мэндийн байгууллагууд нь статистикийн мэдээ, мэдээллийг илгээхдээ өгөгдөл солилцох эрх авсан байна. Өгөгдөл солилцох эрхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Эрүүл мэндийн статистикийн бүртгэлийн програм” хариуцсан мэргэжилтэн энэхүү журмын 2.3-т заагдсан гэрээг үндэслэн олгоно.

- 2.5. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програм нь эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан мэдээлэл хүлээн авах хугацаанд нээлттэй байна.
- 2.6. Журмын 2.5-д заасан хугацаа өнгөрөхөд програмын өгөгдөл хүлээн авах үйл ажиллагаа хаагдана. Энэ үед эрүүл мэндийн байгууллагууд өөрийн хөрвүүлсэн мэдээллийг зөвхөн унших боломжтой байна.

### **Гурав: Эрх, үүрэг**

- 3.1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрх, үүрэг
  - 3.1.1. Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан хугацаанд эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, нэгтгэх, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 3.1.2. Эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програмд нэвтрэх, өгөгдөл дамжуулах эрхийн зөвшөөрлийг олгоно.
  - 3.1.3. Мэдээллийн сангийн батлагдсан загварын дагуу эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан хугацаанд статистик мэдээ, мэдээллийг эрүүл мэндийн байгууллагаар гаргуулна.
  - 3.1.4. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийг хөрвүүлэхэд ашиглагдах сүлжээ, програм хангамжийн шийдлийг боловсруулан гаргана.
  - 3.1.5. Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээллийг хөрвүүлэхтэй холбоотой програмын өөрчлөлтүүдийг тухай бүрд нь хийнэ.
  - 3.1.6. Үндэсний статистикийн хорооноос шинэчилэн баталсан хүн ам зүй, засаг захиргааны нэгжийн кодлолыг тухай бүрд нь програмд оруулж өөрчлөлтийг хийнэ.
  - 3.1.7. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програм, сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдал, нууцлалыг хангаж ажиллана.
  - 3.1.8. Үйл ажиллагаа нь зогссон болон гэрээг зөрчсөн эрүүл мэндийн байгууллагын системд нэвтрэх эрхийг цуцална.
- 3.2. Эрүүл мэндийн байгууллагын эрх үүрэг
  - 3.2.1. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програмд нэвтрэх эрхийн зөвшөөрлийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хүлээн авна.
  - 3.2.2. Эрх нээлгэсэн өдрөөс эхлэн тухайн эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмыг дагаж мөрдөнө.
  - 3.2.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс боловсруулан гаргасан програмын шийдэл, сүлжээг ашиглана.
  - 3.2.4. Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журамд заасан хугацаанд эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийг Эрүүл мэндийн статистикийн мэдээллийн бүртгэл, тайлангийн програмд хөрвүүлэн илгээнэ.

- 3.2.5. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн үнэн бодит байдлыг хариуцна.
- 3.2.6. Үндэсний статистикийн хорооноос шинэчилэн баталсан хүн ам зүй, засаг захиргааны нэгжийн кодлолыг тухай бүрд нь өөрийн байгууллагын бүртгэлийн програмд оруулж өөрчлөлтийг хийнэ.
- 3.2.7. Эрүүл мэндийн статистик мэдээллийн санд нэвтрэх эрхийн зөвшөөрлийг бусдад дамжуулахгүй.

#### **Дөрөв: Мэдээллийн сангийн хадгалалт, ашиглалт**

- 4.1. Эрүүл мэндийн статистик мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагаанд Архивын тухай хуулийг мөрдлөг болгоно.
- 4.2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд нээлттэй мэдээлнэ.
- 4.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудас дах мэдээллийг иргэн, хуулийн этгээд нь сургалт, судалгаа, шинжилгээ, мэдээллийн зорилгоор ашиглаж болно.
- 4.4. Эрүүл мэндийн статистик мэдээний санг ашиглах хүсэлтэй байгууллага Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй зохих хууль, журам дүрмийг баримталсан гэрээ байгуулж, хамтран ажиллана.
- 4.5. Эрүүл мэндийн статистик мэдээллийн сангийн серверийг “Үндэсний дата төв”-д байршуулна.

#### **Тав: Мэдээллийн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглахад хориглох зүйл**

- 5.1. Эрүүл мэндийн статистик мэдээллийн үйл ажиллагаанд дор дурдсан зүйлсийг хориглоно.
  - 5.1.1. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийг хууль бусаар ашиглах, хувийн ашиг сонирхлоор хэрэглэх, бусдад дамжуулах;
  - 5.1.2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, тайлангийн програм, эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн нэгдсэн санд тусгайлан бэлтгэсэн програм болон техникийн тусламжтайгаар хууль бусаар нэвтрэх, програм хангамжийн файлыг устгах, эвдэх, ашиглах боломжгүй болгох, сүлжээг сүйтгэх;
  - 5.1.3. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай ажиллагааг алдагдуулах, эвдэх, гэмтээх;
  - 5.1.4. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн санд хандах эрх бүхий этгээд албан ёсны давуу эрхээ хууль бус үйлдэлд болон хувийн ашиг сонирхлоор ашиглах;
  - 5.1.5. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийн сангийн програм хангамжийг хувилж, тараах, мөн тэдгээрийг гадны сүлжээнд холбох;

#### **Зургаа: Хариуцлага**

- 6.1. Энэхүү журмыг зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол бусад хууль, тогтоомж, журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.2. Энэхүү журамтай холбоотой гомдлыг Эрүүл мэндийн хөгжлийн төв хүлээн авч холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 02 сарын 10-ны өдрийн  
А/Г дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАНГИЙН ПРОГРАМД ИЛГЭЭХ ӨГӨГДЛИЙН ЖАГСААЛТ

### 1. Хувийн хэвшлийн эмнэлэг

- Эмчийн үзлэгийн бүртгэл
- Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн мэдээлэл
- Төрсөн тухай эмнэлгийн гэрчилгээ
- Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас
- Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг мэдээлэх хуудас

### 2. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага

- Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас
- Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг мэдээлэх хуудас
- Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас
- Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ
- Хорт хавдрыг мэдээлэх хуудас
- Эмчийн үзлэгийн бүртгэл
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн мэдээлэл
- Төрсөн тухай эмнэлгийн гэрчилгээ